

Living the Lotus



Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Өмнөх хүнийхээ доторх бурханд мөргөх

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 184 (2020.01)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Шагжамүни бурхан Цагаан Лянхуа Сударт бүх хүнд бурханы гэгээрлийг олно гэсэн баталгаа өгдөг. Гэхдээ тэр нь нөхцөлтэй ба жишээ нь Шаарипүтрад бурхан болох баталгаа өгөхдөө “Шаарипүтра аа, чи бол тоо томшгүй олон бурхдад үйлчлэн, бодисадвагийн үйлд шамдаж, хожмын ертөнцөд Сэцэн Гэрэлт хэмээх нэртэй бурхан болж, хүмүүсийг аврах болно.” гэдэг. Бурханы хутаг олохын тулд хязгааргүй олон бурхадых хүндлэн тахих хэрэгтэй гээд бодохоор бидэнд харь холын хүршгүй зүйл мэт л санагдаж магадгүй.

Гэхдээ түүний үлгэр жишээг Ашид Үл Басагч бодисадвагийн мөргөлийн үйлээр дамжуулан бодитоор ойлгомжтой илэрхийлсэн байдаг. Ашид Үл Басагч бодисадва нь учирсан хүн бүрт мөргөдөг. Өөрийг нь харааж зүхсэн хүний ч, уурлаж бухимдсан хүний ч бурханлаг чанарыг олж хардаг.

Бид бүхэн гэртээ, ажил дээрээ, компани дээрээ, нийгэмд тоолж баршгүй олон хүнтэй уулзаж учирдаг. Хязгааргүй олон бурханыг хүндлэн тахих гэдэг нь тэр олон хүмүүсийн дотор орших бурханд мөргөх явдал гэж хэлж болно. Өөрийгөө хамгаалахаа урьтал болгох бус учирсан бүх хүмүүстээ баяр хөөрийг өгч чаддаг хүн болохыг зорьцгооё. Эхлээд өөрөө гэрэл сацарсан оршихуй болох ёстой хэмээн сэтгэл шулуудсан байхад энэ жил гайхамшигтай нэгэн он болох нь дамжиггүй.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X108-109

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Ашид Үл Басагч бодисадва мэт

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Алга хавсран мөргөж, хүндэтгэлийн сэтгэлээ биеэрээ илэрхийлэх

Шинэ оны баярын мэнд хүргэе.

Энэ жил ч мөн адил үргэлж “Сайн үйл” өрнөсөн, өнгөлөг, утга учиртай баялаг жил байгаасай хэмээн хүснэ. Тэгэхээр “Сайн үйл” гэж юу болох талаар дахин бодож үзье.

Энэ жил “Ничирэн Хутагт мэндэлсний 800 жилийн ой” тохиож байгаа ба тэрбээр “Бурхан багшийн сургаалын гол цөм нь Цагаан Лянхуа Судар ба Ашид Үл Басагч бодисадваг өгүүлэх бүлэгт хэрэгжүүлбэл зохилтой гол үйлийг айлдсан байдаг. Ашид Үл Басагч бодисадва хүмүүсийг хүндлэн дээдэлж байсан нь ямар учиртай болохыг сайтар сайтар бодоод үзээрэй. Шагжамүни бурханы жинхэнэ хүсэл бол энэ бүлгээр дамжуулж үйл хөдлөл хийгээд биеэ авч явах байдал гэсэн хүний зам мөрийг зааж сургах байсан юм.” (Сүшнон хааны бичээс) гэсэн байдаг.

Тэгэхээр Бурхан багшийн сургаалыг суралцагч бидний хувьд амьдралын үндэс болсон өдөр тутмын амьдрал дахь “Сайн үйл” гэж юу болохыг энэхүү “Ашид Үл Басагч бодисадваг өгүүлэх бүлэг”-ээр дамжуулан сургасан гэж ойлгож болох болов уу.

Ашид Үл Басагч бодисадва ямар ч хүнтэй уулзсан алга хавсран мөргөж, хүндэтгэн “Би та нарыг хүндэтгэж байна. Огтхон ч дорд үзэхгүй. Та нар бол бодисадвагийн зам мөрөөр явж, гарцаагүй бурханы хутаг олох хүмүүс учраас тэр билээ.” хэмээн магтдаг байсныг та бүхэн мэдэх байх. Түүгээр ч үл барам тэгж хэлснээсээ болж хичнээн хүнд байдалд орсон ч бусдыг дорд үзэж, уурлаж бухимдаж, занаж зүхэлгүй тэвчээр заан, хэрүүл маргаанаас зайлсхийн холдоод бурханлаг чанарт мөргөх үйлээ тууштай хэрэгжүүлсээр байсан.

Энэ бүлэгт бурханлаг чанараа анзаарч мэдэх, бодисадвагийн үйлийг хэрэгжлүүлэх тухай голчлон айлдсан ба хүмүүний бурханлаг чанарыг хүндлэн алга хавсран мөргөх нь бурханы сургаалд итгэгч хүний гол чанар гэдгийг сургасан. Ашид Үл Басагч бодисадвагийн байр байдлыг сайтар ажиглахад хэлбэрт баригдалгүйгээр сударт өгүүлсэн “Гагцхүү хүндэтгэн мөргөх” хэмээх нэгэн үгэнд агуулагдах гүн утгыг тунгаан бодож, яс махандаа шингэтэл ухаарч хэрэгжүүлэх чухал ба тэр нь өөрөө “Сайн үйл” болдог юм байна хэмээн бодогдоно.

Ашид Үл Басагч бодисадваг өгүүлэх бүлэг ба “Бороонд ч үл ялагдана” шүлэг

Бид бүхэн нар, ус, агааргүйгээр амьдарч чадахгүй нь ойлгомжтой. Өргөн утгаар нь авч үзвэл тийм зүйлүүдэд талархдаг байх нь бидний хувьд эрхэм чухал хүндлэн мөргөх үйл юм. Цаг агаарт гомдоллохгүй байх нь ч гэсэн хүндэтгэн мөргөх үйлийн нэг хэсэг бөгөөд усаа гамтай хэрэглэх, аливаа зүйлийг хий дэмий үрэхгүй байх нь ч бас алга хавсран мөргөхийн нэг хэлбэр биз ээ. Бусдад зовлон тоочин, үглэж гомдоллохгүй байх, хэрүүл хийж, уур бухимдлаа гаргахгүй байх зэрэг нь мөн адил алга хавсран мөргөх үйлийг хэрэгжүүлж буй хэрэг юм. Энэ нь нөгөө хүнийхээ бурханлаг чанарт итгэж, хүндлэх хүнлэг үйл хэрэг гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл өдөр тутмын үйл хөдлөл хийгээд биеэ авч явах байдал, үг хэл нэг бүр нь алга хавсран мөргөх үйл байдаг. Өдөр тутмын үйл хөдлөлөөрөө дамжуулж бид өөрийн бурханлаг чанарыг ухаарч, мөн хүмүүст ч бурханлаг чанарыг нь ухааруулж байдаг.

Хүүхдийн зохиолчоороо танигдсан Миязава Кэнжигийн “Бороонд ч үл ялагдана” шүлгийн нэг бадагт “Бүгдэд хэрэггүй амьтан гэгдэж, Сайшаагдах ч үгүй, Зовох ч үгүй, Тийм хүн би байхсан” гэсэн байдаг. Ашид Үл Басагч бодисадва бүлэг амьдралд нь маш ихээр нөлөөлсөн Кэнжигийн хүсэл ба амьдралыг харуулсан бадаг гэдэг. Тэр утгаар нь энэ шүлгийг “Ашид Үл Басагч бодисадваг өгүүлэх бүлэг”-ийн утга санаатай зүйрлүүлэн дахиад уншиж үзэхэд надад өмнө хэзээ ч төрж байгаагүй гүн сэтгэгдэл төрсөн юм. Учир нь уг шүлэг бол Цагаан Лянхуа Сударт итгэж биширсэн Кэнжигийн аядуу зөөлөн үгээр зохиогдсон “Ашид Үл Басагч бодисадваг өгүүлэх бүлэг” тэр чигээрээ бөгөөд Цагаан Лянхуа Судрыг мэддэггүй хүн уншсан ч Ашид Үл Басагч бодисадвагийн амьдрал, бодисадва хүний үйл хөдлөл хийгээд байр байдлыг сайтар ойлгохоор санагдсан.

“Хүсэл шунал үгүй, Уур уцаар огт үгүй” гэдгийг тайлбарлалтгүй байх.

“Алив бүхэнд, Өөрийгөө л бодолгүй” гэсэн нь “Эхлээд бусдын төлөө” гэсэн санааг илэрхийлж,

“Ган зудын үед, Нулимсаа барна” гэсэн нь хүний хүчээр яаж ч эс чадах зовлон зүдгүүртэй нүүр тулсан нэгнийг аяархан тэврэх мэт энэрэн нигүүлсэхийг илэрхийлснээс өөрцгүй.

Та бүхэн ч бас боломж гарвал энэ шүлгийг бясалган уншиж үзээрэй.

«Косей» 2021 оны 1 дүгээр сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Түүнчлэн Ирсэний рид хувилгаан хүчийг өгүүлэх 21 дүгээр бүлэг

Уг бүлэгт Шагжамүни бурханаас эхлээд олон бурхад гайхамшигт рид хувилгаан хүчийг үзүүлээд, “Өдийг хүртэл сургаалыг олон янзаар айлдаж байсан боловч жинхэнэ үнэн бол үргэлж ганц байдаг.” хэмээх “Нэгэн Бурханы Хөлгөн”-ы талаар айлддаг ба сонссон олон хүчтэй сэтгэгдэлд автаж буй тухай өгүүлдэг.

Арван рид хувилгаан хүч

Рид хувилгаан хүч нь нийт 10 төрөл байдаг.

Нэгдүгээрт, “Хэлний эрхтэнээр Эсэрваа тэнгэрт хүрэх”. Бурханы айлдах бүх зүйл жинхэнэ үнэн бөгөөд түүний зорилго ганц болохыг харуулсан. Энэ бол Шагжамүни бурхан ч Язгуурын Бурхан ч нэгэн цул бөгөөд бидний итгэх зүйл цор ганц болохыг илэрхийлсэн. (Хоёр үүд нэг сүсэг бишрэл)

Хоёрдугаарт, “Хамаг үсний нүхнээс хэмжээлшгүй тоолшгүй өнгө төгөлдөр гэрлийг сацруулах”. Бурханы айлдсан сургаал энэ ертөнцийн аливаа амьтай бүхний хувьд гэрэл гэгээ нь болдог бөгөөд төөрөгдлийн харанхуй мананг хага цохьдог гэдгийг харуулсан. Шагжамүни бурханы сургаал ч Язгуурын Буддагийн сургаал ч учир зүйн хувьд нэгэн адил болохыг илэрхийлсэн. (Хоёр үүд нэг учир шалтгаан)

Гуравдугаарт, “Олон бурхадын хоолой засах дуун”. Бүх бурханы сургаал нэг зүйлд нэгддэг болохыг харуулсан бөгөөд Гурван Хөлгөн бол Нэгэн Бурханы Хөлгөн (Хоёр үүд нэг сургаал) гэсэн утгатай.

Дөрөвдүгээрт, “Олон бурхадын хуруугаа инчдэх чимээ”. “Бүгд хамтдаа энэхүү сургаалыг түгээн дэлгэрүүлье.” гэсэн бурханы амлалтыг илэрхийлсэн бөгөөд өөрөө хийгээд өрөөл бусад нь нэгэн бүхэл гэсэн утгатай. (Хоёр үүд нэг хүн)

Тавдугаарт, “Зургаан зүйлээр дэнслэн чичрэх”. Тэнгэр, газар дэнслэн хөдөлж, чичирсэн гэсэн үг. Энэ бол бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэхийг илэрхийлсэн. (Хоёр үүд нэг үйл)

Зургаадугаарт, “Бурхадыг харах их учрал”. Хамаг амьтад бүхэн бүгд Бурхан будда, бодисадваг харж чадсан гэсэн үг. Энэ нь яг одоо хүмүүсийн сургаалыг ойлгох чадвар янз бүр байж болох ч, ирээдүйд бол бүгд адил бурханы хутгийг олж чадах түвшинд хүрнэ гэсэн утгыг илэрхийлсэн. (Ирээдүйд нэгэн ижил түвшинд хүрэх)

Долоодугаарт, “Агаар тэнгэрт дуулах дуун”. Цагаан Лянхуа Судрын сургаал л бүгдийг аварч, амьдруулах сургаал гэдгийг харуулсан. Түүнчлэн ирээдүйд даян дэлхийн бүх шашин нэг зорилгын төлөө нэгдэхийг илэрхийлсэн. (Ирээдүйд ганцхан сургаал оршино) Үүнийг л шашны хамтын ажиллагааны хамгийн төгс дүр төрх гэж хэлж болох биз ээ.



Наймдугаарт, “Хотлоор мөргөмүү”. Бүх амьд амьтад “Намо Шагжамүни.” хэмээн аялгуулан дуудсан гэсэн үг. Энэ бол ирээдүйд бүх хүн Цагаан Лянхуа Судрын сургаалд итгэж, төгс мөн чанарыг цогцлооно гэсэн утгыг илэрхийлсэн. (Ирээдүйд нэг хүн болох)

Есдүгээрт, “Алс холд сарних”. Бурхан буддад залбиран мөргөж, чин сэтгэлээсээ талархалаа илэрхийлж байгаагийн бэлгэ тэмдгийг харуулсан бөгөөд ирээдүйд амьтай бүхэн Бурхан багшийн сургаал номын дагуу үйл хийнэ гэсэн утгыг илэрхийлсэн. (Ирээдүйн нэг үйл)


Аравдугаарт, “Нэгэн бурханы оронд очих”. Бүх дэлхий нэгэн бүхэл бурханы орон болно гэсэн үг. Энэ бол дэлхий тэр аяараа жинхэнэ үнэний дагуу агуу энх тайван ертөнц болохыг илэрхийлсэн утга юм. (Ирээдүйд нэгдмэл болох)

Ийнхүү Цагаан Лянхуа Судрын онцлогийг тал бүрийн өнцгөөс дүрсэлсэн бөгөөд үүгээр дэлхий ертөнцийн туйлын төгс хэлбэрийг илэрхийлсэн.

Дөрвөн мөр гол сургаал

Арван их рид хувилгаан хүчийг үзүүлсэн Шагжамүни бурхан улмаар дараахийг айлддаг.

“Цагаан Лянхуа Судрын ач буяны гол утга санааг нэгтгэн хэлбэл, Түүнчлэн Ирсэний гэгээрсэн бүх сургаал (Түүнчлэн Ирсэний баригч бүх сургаал) ба Түүнчлэн Ирсэний өөрөө мэдэн захиран зарцуулах эрх бүхий бүх үйл (Түүнчлэн Ирсэний эрх чөлөөт рид хувилгаан хүч) ба Түүнчлэн Ирсэний цээжинд бялхсан бүх чухал сургаал (Түүнчлэн Ирсэний бүх нууц агуулах) ба Түүнчлэн Ирсэний бие туулж өнгөрүүлсэн бүх дотоод хийгээд





гадаад гүн гүнзгий туршлага бүгдийг (Түүнчлэн Ирсэний гүн гүнзгий бүхэн) энэ сургаалд дэлгэн тайлбарласан.”

Үүнийг дөрвөн мөр гол сургаал гэх ба Цагаан Лянхуа Судрын бүх ач буяныг нэгтгэн багцалсан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл сударт агуулагдах хэмжээ хязгааргүй үнэ цэнэ, сургаалын төгс төгөлдөр байдлыг энд Шагжамүни бурхан дахин өөрийн үгээр батлан хэлсэн байгаа юм.

Сургаалыг тусгайлан итгэмжлэн даалгах ба зам мөрийн газар


За ингээд энд зүрх сэтгэлдээ ягштал суулгах ёстой чухал зүйлийг хэлье. Тэр бол Дээд Явдалт, Хязгаалшгүй Явдалт, Ариун Явдалт, Амар Амгалан Явдалт гэсэн дөрвөн бодисадвагаас авахуулаад бусад бодисадва нарт энэхүү Цагаан Лянхуа Судрыг түгээн дэлгэрүүлэх үүргийг даатгахын тулд Шагжамүни бурхан дээрх арван их рид хувилгаан хүчний тухай номлож, дөрвөн мөрт гол сургаал хэмээн Цагаан Лянхуа Судрын ач буяныг нэгтгэн дүгнэсэн учиртай. Энэ бүлгийг дээр үеэс л “Бодисадва нарт итгэмжлэн даалгах” бүлэг хэмээгээд, дараах “Итгэмжлэн даалгасныг өгүүлэх 22 дугаар бүлэг”-ийг “Нийтэд сургаалыг түгээн дэлгэрүүлэхийг даатгах бүлэг” гэдэг. Тэр утгаараа бодисадва нарт тусгайлан сургаалыг түгээн дэлгэрүүлэхийг даалгасан маш чухал хэсэг гэж үздэг.

Бодисадвагийн үйл болгож дахин гурвантаа “Таван төрлийн номын багш”-ийн үйлийг айлдаад, Шагжамүни бурханы сургаалыг түгээн дэлгэрүүлэх захиасыг хүлээж авч, бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэгч газар л бурханы номд суралцах газар (Даруй номын мөрд орох) мөн гэсэн.

Өөрөөр хэлбэл Цагаан Лянхуа Судрын сургаал тэр чигээрээ буюу “Сургаалыг хэрэгжүүлэх” явдал нь хамгийн үнэ цэнэтэй юм. Эдгээр нь газар доороос хөөрөн гарч ирсэн бодисадва болох бид бүхний сүсэг бишрэл бүхий амьдралын үндэс болсон эрхэм чухал зүйлс учраас улам зүрх сэтгэлдээ сийлэн үлдээх ёстой билээ.



«Лянхуан Гурамсан Сударын бүлэр тус бүрийн тайлбар», Нивано Никкёо
Косей хэвлэлийн компани, 1991 он, X-188-192



Олон улсын хэлтсийн даргын булан


Акагава Кэйичи даргын танилцуулга

1960 онд Акита мужид төрсөн. 1986 онд Гакүрин сургуульд элсэж Рисшо Косей Кай байгууллагын ажилтан болсон. Сургуулиа төгссөнийхөө дараа Гадаад хэргийн хэлтэс, WCRP (Дэлхийн Шашны Энх Тайвны Чуулга)-ын Япон дахь төв зэрэг хэлтсүүдэд олон жил ажиллаж, шашны хамтын ажиллагаа, энх тайвны үйл хэрэгт хувь нэмрээ оруулсан. Швед улсын Жинев хотод 3 жил ажиллаж амьдарсан. 2007 онд Гадаад хэргийн хэлтсийн дэд дарга, 2015 онд Мэгүро салбарын тэргүүнээр тус тус ажиллаж байсан ба 2020 оны 12-р сарын 1-ээс Олон улсын хэлтсийн даргаар томилогдон ирээд байна.



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: dharmasa@rksabuddhistcenter.org
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: kosekaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/RKUnitedKingdom>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>